



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2018 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/210

Улаанбаатар хот

Төрийн аудитын байгууллагын ажилтны  
мөрдөх ёс зүйн дүрэм батлах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, 7.6, 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. "Төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх ёс зүйн дүрэм"-ийг хавсралтаар баталсугай.

2. "Төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх ёс зүйн дүрэм"-ийг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг Төрийн аудитын байгууллагын нийт албан хаагчид, Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс төрийн аудитын үйл ажиллагаанд оролцож буй иргэн, хуулийн этгээдэд тус тус үүрэг болгосугай.

3. Төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх ёс зүйн дүрмийг Төрийн аудитын байгууллагын нийт албан хаагчид болон Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс аудитын үйл ажиллагаанд оролцож буй иргэн, хуулийн этгээдийн ажилтнуудад судлуулан танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газар, Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга/захирал-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2003 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаартай "Ёс зүйн дүрэм батлах тухай", 2013 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн "Ёс зүйн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

## ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫ МӨРДӨХ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

УХАА 123

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага /ИНТОСАИ/-ын баталсан стандарт (АДБОУС 30)-ын Ёс зүйн дүрэм болон тэдгээрт нийцүүлэн гаргасан Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал зэрэг нь Төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх ёс зүйн дүрмийн эрх зүйн үндэс байна.

1.2. Энэхүү дүрмийн зорилт нь Төрийн аудитын байгууллага болон Төрийн аудитын байгууллагын ажилтны нэр төрийг хамгаалах, Төрийн аудитын чиг үүргийг хэрэгжүүлэхэд дагаж мөрдөх ёс зүйг тогтоон хэвшүүлэх, хууль тогтоомжид заасан болон энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг дагаж мөрдүүлэхэд оршино.

1.3. Энэхүү дүрмийн зорилго нь Төрийн аудитын тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам болон Төрийн аудитын байгууллагын ажилтны тангарагыг сахин хамгаалахад оршино.

1.4. Хуульд тусгайлан ёс зүйн зөрчил болохоор заасан болон энэ дүрмээр тогтоосон хэм хэмжээг санаатай буюу санамсаргүй зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг "ёс зүйн зөрчил" гэж үзнэ.

1.5. Төрийн аудитын байгууллагын ажилтан албан үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан мэргэжил, ур чадвар, дадлага, туршлагатай холбоотой алдаа нь ёс зүйн зөрчилд хамаарахгүй.

### Хоёр.Хамрах хүрээ

2.1. "Төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх ёс зүйн дүрэм"-ийг Монгол Улсын Ерөнхий аудитор, Үндэсний аудитын газар, Аймаг, Нийслэл дэх Төрийн аудитын газрын албан хаагчид, тус байгууллагын нэрийн өмнөөс төрийн аудитын үйл ажиллагаанд оролцож буй этгээд /цаашид "Төрийн аудитын байгууллагын ажилтан" гэх/-т нэгэн адил дагаж мөрдөнө.

2.2. Дүрмийн 2.1.-т заасан этгээд Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага /ИНТОСАИ/-ын баталсан (АДБОУС 30)-ын Ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх бөгөөд энэхүү дүрмийн салшгүй нэг хэсэг байна.

### Гурав.Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх зарчим

3.1. Төрийн аудитын байгууллагын ажилтан ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэхэд дараах зарчмыг баримтална:

- 3.1.1. хууль дээдлэх;
- 3.1.2. шударга байдлыг хангах;
- 3.1.3. хараат бус бодитой ба тэгш байдал;
- 3.1.4. төрийн болон албаны мэргэжлийн нууцыг хадгалах;
- 3.1.5. итгэл хүлээх;
- 3.1.6. хүнлэг энэрэнгүй;

## Дөрөв. Ёс зүйн хэм хэмжээ

4.1. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь төрийн тусгай албан хаагч болохын хувьд Төрийн аудитын чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дагаж мөрдвөл зохих зан үйл, хэм хэмжээний нийлбэр цогцыг төрийн аудитын байгууллагын ажилтны мөрдөх ёс зүйн хэм хэмжээ гэнэ.

4.2. Энэхүү дүрмийн гуравдугаар бүлэгт заасан зарчмын хүрээнд дор дурдсан хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

4.2.1. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж /нөхрийн хэрэг бүтвэл өөрийн хэрэг бүтнэ гэсэн үзэл санааны дор/, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;

4.2.2. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь хууль дээдлэх, мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх, үнэнч шударга байх, төрийн албаны нэр хүндийг ямагт дээдлэн, ёс суртахууны болон мэргэжлийн өндөр шаардлагыг хангаж ажиллах;

4.2.3. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь өөрийн өмчийн байдал, тэдгээрт орсон өөрчлөлт, орлогын талаар хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;

4.2.4. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь шалгагдагч байгууллага болон холбогдох бусад этгээдээс хараат бусаар ажиллах;

4.2.5. Төрийн аудитын байгууллагын ажилтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө шалгагдагч байгууллага, холбогдох бусад этгээдээс мөнгө, үнэ цэнэ бүхий бэлэг, дурсгалын эд зүйл, шан харамж авахгүй байж, өөртөө болон гэр бүл, ах дүү, төрөл садандаа үнэгүй буюу хөнгөлөлттэй үйлчлүүлэх эрх, амлалт авахаас татгалзах замаар ашиг сонирхлын болзошгүй зөрчлөөс зайлсхийж, хараат бус байдлаа хамгаалах;

4.2.6. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь шалгагдагч байгууллагаас ажил эрэлхийлж байгаа тохиолдолд энэ тухайгаа удирдлагад мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ажилд орох сонирхолтой байгууллагадаа аудит хийж, тэднээс ажил, албан тушаал горилохгүй байх;

4.2.7. Төрийн аудитын байгууллагын ажилтан Төрийн аудитын үйл ажиллагаанд оролцоходоо нотлох баримтад суурилсан үнэн зөв дүгнэлт гаргах үүрэгтэй;

4.2.8. Төрийн аудитын байгууллагын ажилтан олон нийтийн цахим мэдээ, мэдээллийн сүлжээ ашиглахдаа байгууллагын нэр хүндэд харшилсан, эсхүл үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх санал, сэтгэгдэл, зураг, дуу, дүрс бичлэг болон бусад хэлбэрийн мэдээ, мэдээлэл байршуулахгүй байх;

4.2.9. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь удирдах, удирдуулах ёс, төрийн албаны дүрэм журмыг чанд сахин, бие биеэ харилцан хүндэтгэж, өөр хоорондоо нөхөрсөг, шударга, хамтач, ажил хэрэгч харилцаатай байх;

4.2.10. Төрийн аудитын байгууллагын ажилтан удирдах ажилтны хуульд нийцсэн үүрэг даалгавар, шийдвэр, үндэслэл бүхий зөвлөмжийг биелүүлэх;

4.2.11. Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

4.2.12. Удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх;

4.2.13. Энэхүү дүрмийг зөрчсөн, зөрчигдөж буй талаар, мэдсэн талаар энэ тухай Төрийн аудитын байгууллагын ёс зүйн зөвлөл /албан тушаалтан/-д мэдэгдэх;

4.2.15. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь албан үүргээ гүйцэтгэх явцад болон ажлын хамт олонтой харилцахдаа /хувиа хичээх үзэлд автахгүй байх/ бусдын санаа бодлыг хүндэтгэн сонсож, хамт олны дунд халуун дулаан уур амьсгал түгээж ажиллах;

4.2.16. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь хөндлөнгийн аливаа нөлөөнд үл автан, гагцхүү хуульд захирагдан, аудиторын ёс суртахууны хэм хэмжээг чанд сахин биелүүлж, албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхдээ шалгагдаж буй байгууллагыг хардаж сэрдэх биш дэмжин туслах чиг хандлагтай ажил үүргээ гүйцэтгэх үүрэгтэй гэдгээ ямагт ухамсарлана;

### **Тав. Хориглох зүйлс**

5.1. Төрийн аудитын байгууллагын ажилтан ашгийн болон ашгийн бус сонирхол бүхий байгууллага, хөтөлбөр, үйл ажиллагаанд аудит хийхийг хориглоно. "Ашгийн болон ашгийн бус сонирхол" гэдэгт дараах нөхцөл байдал хамаарна. Үүнд:

5.1.1. аж ахуйн нэгж, байгууллагын хувьцаа эзэмшигч нь байх;

5.1.2. шалгагдагч байгууллагаас ямар нэгэн төрлийн цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж авдаг байх;

5.1.3. шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд хөрөнгө оруулсан, түүнээсээ орлого олдог байх;

5.1.4. шалгагдагч байгууллагад эхнэр, нөхөр, хүүхэд нь ажилладаг байх;

5.1.5. шалгагдагч байгууллагад ажилтан, захирал, удирдах зөвлөлийн дарга, гишүүн, зөвлөхөөр давхар ажилладаг байх;

5.2. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь улс төрийн байгууллагад манлайлах үүрэг гүйцэтгэх, гишүүн байх, эсхүл албан тушаал хаших, улс төрийн байгууллага болон нийтийн албан тушаалд нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд оролцох, хандив өгөх зорилгоор бусдыг уриалах, улс төрийн байгууллага болон нийтийн албанд нэр дэвшигчийн санхүүжүүлсэн, зохион байгуулсан, санаачилсан арга хэмжээнд дэмжиж оролцох, тэдний өмнөөс илтгэл тавих, үг хэлэх, улс төрийн байгууллагаас дэмжлэг, хандив хүсэх, хүлээн авах, ашиглах болон улс төрийн аливаа үйл ажиллагаанд оролцохыг хориглоно;

5.3. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь өөрт олгогдсон бүрэн эрхийн хүрээнд бусдыг аливаа хэлбэрээр ялгаварлах, басамжлах, нэр төрийг нь гутаан доромжлох, дарамт шахалт үзүүлэх, чирэгдүүлэх, хүнд суртал гаргах түүнчлэн эдгээртэй адилтгах үйл ажиллагаанд дэмжиж оролцохгүй байх;

5.4. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоос бусад тохиолдолд албаны үнэмлэх, тэмдэг ашиглан өөртөө давуу байдал бий болгох, бусдад ашиглуулах, албан үүрэгтэй холбоогүй иргэний үүрэг, хувийн шинж чанартай хэрэгцээнд ашиглах болон барьцаа болгон үлдээхгүй байх;

5.5. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь ажлын байранд, албан үүргээ гүйцэтгэх, албан томилолтоор ажиллах үедээ буюу ажлын цагаар архи, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, хэрэглэсэн үедээ ажлын байранд нэвтрэхгүй байх;

5.6. Төрийн аудитын байгууллагын ажилтан танил тал, найз нөхөд гэр бүл, төрөл садны хүмүүс ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг хориглоно;

5.7. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь шалгагдагч байгууллагын ажилтнуудаар дайлуулж, цайлуулах, зугаа цэнгээний арга хэмжээнд нь оролцохыг хориглоно;

5.8. Төрийн аудитын байгууллагын ажилтан хувийн сонирхлоор аудитын тайлан, дүгнэлтэд хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно;

5.9. Төрийн аудитын байгууллагын ажилтан *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд заагдсанаас өөр бусад ажил албан тушаал давхар эрхлэхийг хориглоно;*

5.10. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь аудитын явцад олж авсан бүрэн бус мэдээлэлд тулгуурлан урьдчилсан дүгнэлт хийж байгууллага, хувь хүний нэр хүндэд халдах, олон нийтэд мэдээллэхийг хориглоно;

5.11. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь аудитын явцад олж авсан мэдээлэл, өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн байгууллага, хувь хүн, төрийн болон албаны, нууцыг задруулах, хувийн ашиг сонирхлоор өөрт болон бусдад амаар, бичгээр болон бусад хэлбэрээр дамжуулахыг хориглоно;

### **Зургаа. Ёс зүйн хэм хэмжээ болон хориглох зүйлс зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

6.1. Төрийн аудитын байгууллагын ажилтан ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол тухайн этгээдийн гаргасан зөрчлийн шинж байдлыг нь харгалзан Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах тухай Ёс зүйн зөвлөлийн санал дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулж, хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэнэ.

6.2. Ёс зүйн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол харьяаллын дагуу шалгуулахаар холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

6.3. Төрийн аудитын байгууллагын нэрийн өмнөөс төрийн аудитын үйл ажиллагаанд оролцож буй иргэн, хуулийн этгээдийн гаргасан зөрчлийн шинж байдлыг харгалзан үзэж тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, тендерт оролцох эрхийг хязгаарлах саналыг Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.4. Энэхүү дүрмийн 6.2, 6.3-т заасны дагуу холбогдох байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн нь тухайн этгээдэд сахилгын шийтгэл ногдуулахгүй байх үндэслэл болохгүй.

6.5. Ёс зүйн зөрчлийг шалгасан албан тушаалтан шалгалтын материалыг зөрчил гаргасан албан хаагчид урьдчилан танилцуулж, нэмэлт тайлбар, гомдол гаргах боломжийг олгоно.

6.6. Төрийн аудитын байгууллагын ажилтан нь сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл хуульд заасны дагуу гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагад 30 хоногийн дотор гомдол гаргаж болно.

ХА0122